

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дэлгэр сумын Гуулин тосгоны төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2024/19/-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Алтай хот
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа
Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг
Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Цэрэнханд
Утас: 99086371 Цахим хаяг: tserenkhandd@audit.gov.mn
Аудитор: С.Санчирмаа
Утас: 99282488 Цахим хаяг: sanchirmaas@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.03.25 № 140

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Дэлгэр сумын Гуулин тосгоны Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Дэлгэр сумын Гуулин тосгоны Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 4.4 сая төгрөгийн зөрчил илэрсэн, үйл ажиллагааны орлого 0.3 сая төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамж 0.1 сая төгрөгөөр, газрын төлбөр 0.2 сая төгрөгөөр, торгуулийн орлого 0.9 сая төгрөгөөр тус тус тасарсан, Батлагдсан төсвөөс төсөвт байгууллагуудад санхүүжилтийг олгохдоо 7.7 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгосон, малын тоо, толгойн албан татварын орлого 1.7 сая төгрөгийг ОНХС-д төвлөрүүлээгүй нийт 15.3 сая төгрөгийн зөрчил нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 41 дүгээр зүйлийн 41.2.1, 60 дугаар зүйлийн 60.2.8 дахь заалт, Дэлгэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 49 дүгээр тогтоолын 1 дэх заалттай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Сангийн яамны 2024 оны 02 дугаар сарын 6-ны өдрийн 10/683 дугаар тоот албан бичгийн хавсралтаар Төсвийн тухай хуулийн дагуу 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргах чиглэлийг хүргүүлжээ.

0702900444

Аудитын гол асуудал

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны зардлын нийт гүйцэтгэл өмнөх оноос 15.8 сая төгрөг буюу 2.4 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа нь төрийн албан хаагчдын цалин нэмэгдсэнтэй холбоотой байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь тайлант онд 7 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 42 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, биелэлтийг 97.5 хувийн биелэлттэй гаргаж, сумын Засаг даргаас 97.5 хувиар дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Г.ГҮНЖИДМАА



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

(мянган төгрөгөөр)

	Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	41,266.4	73,530.0
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	298,009.9	269,808.4
	Нийт хөрөнгийн дүн	339,276.3	343,338.4
	Нийт өр төлбөрийн дүн	337,639.1	339,012.8
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	339,276.3	343,338.4
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	41,266.4	73,530.0
Үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	850,229.5	375,546.5
	Үйл ажиллагааны зардлын дүн	648,884.7	374,172.8
	Үйл ажиллагааны үр дүн	201,344.8	1,373.7
	Үйл ажиллагааны бус үр дүн	1,484,672.7	-
	Үйл ажиллагааны нийт үр дүн	(1,283,327.9)	1,373.7
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	(1,283,327.9)	337,639.1
	НББ-ын өөрчлөлт	337,639.1	-
	Тайлант оны үр дүн	(1,283,327.9)	1,373.7
	Эцсийн үлдэгдэл	337,639.1	339,012.8
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	617,351.8	340,287.8
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	622,203.9	321,246.3
	Үйл ажиллагааны ЦМГ	(4,852.0)	19,041.6
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-	(27,230.6)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	(4,852.0)	(8,189.1)
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	44,070.6	39,218.5
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	39,218.5	31,029.4
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	279,524.1	273,035.1
	Урсгал зардал	279,524.1	273,035.1
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	279,524.1	273,035.1
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	279,524.1	273,035.1
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	279,524.1	273,035.1
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 7,595.0 мянган төгрөгийн 3 алдаа илрүүлснийг аудитын явцад залруулсан байна.

Аудитаар нийт 15,343.6 мянган төгрөгийн 5 зөрчил илрүүлснээс, 2,077.0 мянган төгрөгийн төлбөрийн акт, 13,266.6 мянган төгрөгийн 3 зөрчил арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлсэн байна.

Залруулагдаагүй зөрчлийн дүн 15,343.6 мянган төгрөг нь тогтоосон материаллаг байдлын түвшин 5,590.5 мянган төгрөгөөс давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

5.1.1 Харьяа байгууллагууд

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 1 төсвийн байгууллага, 4 байгууллагын (Сургууль, Соёлын төв, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв) тогтмол зардал нэгтгэсэн байна.

Аудитаар Захирагчийн албаны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийж “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн ба сумын Сургууль, Соёлын төв, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн тогтмол зардлыг аудитын түүвэрт хамруулсан.

5.1.2 Аудитаар Гуулин тосгоны ажлын албаны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил

Аудитаар төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зарлагыг 7,595.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан 3 алдааг залруулж, 4,362.1 мянган төгрөгийн 2 зөрчил илрүүлж, 321.1 мянган төгрөгийн төлбөрийн акт, 4,041.0 мянган төгрөгийн албан шаардлагыг хүргүүлсэн байна.

5.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 15,343.6 мянган төгрөгийн 5 зөрчил илрүүлснээс 2,077.0 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 13,266.6 мянган төгрөгийн 3 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж байна.

5.1 Төлбөрийн акт

1.Малын тоо, толгойн албан татварын орлого 1,755.9 мянган төгрөгийг ОНХС-д төвлөрүүлээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.8-д "Малын тоо толгойн албан татварын орлого. Уг орлогын эх үүсвэрийг бэлчээрийн менежментийг сайжруулах, бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын чанарыг сайжруулах, гэмт халдлага, гамшгаас хамгаалах, хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх, малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн нөөц бүрдүүлэх, байгаль орчныг хамгаалах, хортон мэрэгчидтэй тэмцэх, малчдад зориулсан сургалт, сурталчилгааны зардалд

зарцуулна." заалтыг зөрчсөн, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлээгүй малын хөлийн албан татварыг төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

5.2.1 Албан шаардлага

1. Үйл ажиллагааны орлого орлого 328.8 мянган төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамж 94.9 мянган төгрөгөөр, газрын төлбөр 198.9 мянган төгрөгөөр, торгуулийн орлого 920.0 мянган төгрөгөөр тус тус тасарсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", Дэлгэр Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 49 дүгээр тогтоол, заалтыг зөрчсөн, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр ханган ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

2. Батлагдсан төсвөөс төсөвт байгууллагуудад санхүүжилтийг олгохдоо 7,683.0 мянган төгрөгийн санхүүжилт дутуу олгосон нь Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.16-т "төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн байгууллага, бусад этгээдэд улсын төсвөөс санхүүжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг батлагдсан төсвийн дагуу олгох; 41 дүгээр зүйлийн 41.2.5-т "энэ хуулийн 37.1.8-д заасан эрхийн хүрээнд төсвийн байгууллагын зардлыг санхүүжүүлэх;" Дэлгэр Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 49 дүгээр тогтоолыг зөрчсөн, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийн дагуу төсвийн олгож байх албан шаардлага хүргүүлсэн.

3. Харьяа байгууллагуудын аудитаар 321.1 мянган төгрөгийн төлбөрийн акт, 4,041.0 мянган төгрөгийн зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх албан шаардлагыг холбогдох байгууллагад хүргүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.37-д "төсвийн төвлөрүүлэн захирагч" гэж төсвийн ерөнхийлөн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, төсвийн шууд захирагчид хуваарилах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг", 5 дугаар зүйлийн 5.1-д "Төсөв нь Улсын болон Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх бөгөөд төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална: 5.1.3 санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.6.1-д "төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх", Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4-т "Агентлагийн зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга нэгжийнхээ өдөр тутмын үйл ажиллагааг удирдаж, үр дүнг агентлагийн даргын өмнө хариуцна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд тавих санхүүгийн дотоод хяналтыг сайжруулж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Дэлгэр сумын Гуулин тосгоны төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Дээрх албан шаардлагын биелэлтийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруу лаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	То о	Дүн	Тоо	Дүн	То о	Дүн	Тоо	Дүн
Дэлгэр сумын Гуулин тосгоны ТТЗ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дэлгэр сумын Гуулин тосгоны Захирагчийн ажлын алба	3	7,595.0	-	-	3	7,595.0	3	7,595.0	-	-	-	-
Дүн	3	7,595.0	-	-	3	7,595.0	3	7,595.0	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн										
Дэлгэр сумын Гуулин тосгоны ТТЗ	3	10,981.52	1	1,755.90	2	9,225.62	-	-	-	-	-	-
Дэлгэр сумын Гуулин тосгоны Захирагчийн ажлын алба	2	4,362.1	1	321.1	1	4,041.0	-	-	-	-	-	-
Дүн	5	15,343.6	2	2,077.0	3	13,266.6	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дэлгэр сумын Гуулин тосгоны ТТЗ	-	-	-	-	-	-	-	-
Дэлгэр сумын Гуулин тосгоны Захирагчийн ажлын алба	-	-	-	-	-	-	-	-

Дэлгэр сумын Гуулин тосгоны төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Дүн	-	-	-	-	-	-	-	-
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дэлгэр сумын Гуулин тосгоны ТТЗ	-	-	-	-	-	-	-	-
Дэлгэр сумын Гуулин тосгоны Захирагчийн ажлын алба	-	-			-	-	-	
Дүн	-	-	-	-	-	-	-	-
Нийт дүн	-	-	-	-	-	-	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	Дэлгэр сумын Гуулин тосгоны ТТЗ	1	1	-	-	-	1	-	-
2	Дэлгэр сумын Гуулин тосгоны Захирагчийн ажлын алба	1	1			1	-	-	-
	НИИТ	2	2	-	-	1	1	-	-